

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говийн их дархан цаазат газрын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааны 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/43/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Алтай хот

2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Атарцэцэг

Утас: 88984411 Цахим хаяг: atartsetsegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2024/43/НА-СТА-ТШЗ



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.17 № 30

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говийн их дархан цаазат газрын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говийн их дархан цаазат газрын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааны 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Говийн их дархан цаазат газрын "Б" хэсгийн хамгаалалтын захиргааны улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлэн 1835.7 мянган га болж, хамгаалалттай газар нутгийн дотоод бүсчлэлийн ажлыг шинэчлэн тогтоолгосон байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан 102,961.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авч, 10,188.0 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 1 хөтөлбөр, 7 зорилт, 25 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 23 арга хэмжээг бүрэн, 1 арга хэмжээг 50.0 хувь, 1 арга хэмжээг 40.0 хувь буюу нийт дүнгээр 89.6 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

07020160

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	144,088.5	171,591.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	356,178.6	371,210.3
	Нийт хөрөнгийн дүн	500,267.1	542,801.5
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	500,267.1	542,801.5
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	500,267.1	542,801.5
	Үйл ажиллагааны орлогын дүн	564,318.8	1,011,148.1
	Үйл ажиллагааны зардлын дүн	537,177.6	968,613.7
	Үйл ажиллагааны үр дүн	27,141.2	42,534.5
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	27,141.2	42,534.5
	Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	500,267.10	500,267.1
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	473,125.9	500,267.1
	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-
	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-
	Тайлант оны үр дүн	27,141.2	42,534.5
	Эцсийн үлдэгдэл	500,267.1	542,801.5
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	598,984.8	859,513.2
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	480,324.0	859,513.2
	Үйл ажиллагааны ЦМГ	118,660.8	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(118,660.8)	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	432,500.4	778,294.2
	Урсгал зардал	432,500.4	778,294.2
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	432,500.4	778,294.2
	Улсын төсвөөс санхүүжих	432,000.4	777,232.2
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	-
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	500.0	1,062.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 58,787.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Хуультай холбоотой:** Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 15,000.0 мянган төгрөгийг нөхөн шивүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтыг зөрчсөн байна.
- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг 11,792.5 мянган төгрөгөөр, бараа материалын тодруулга тайланд 31,995.0 мянган төгрөгийн өвс, хатуу түлшийг зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна

Залруулагдаагүй нийт 13,898.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 13,898.0 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрч 1,441.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн 2 акт тогтоож, 12,456.6 мянган төгрөгийн 3 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Ажилчдын үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 1,020.9 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно.", Тухайн цалин, нэмэгдэл тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрийг нэмж тусгана" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдын амралтын цалинтай давхардуулан олгосон цалинг төлүүлж орон нутгийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

2. Ажилчдын цалингаас аудитын акт суутгахдаа 420.5 мянган төгрөгийг илүү суутгасан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн 119.1-т "Ажил олгогч ажилтны цалин хөлсийг бүрэн хэмжээгээр нь олгох бөгөөд дараах тохиолдолд суутгал хийж болно: 119.1.1. ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээний хохирлыг ажилтнаар нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн шийдвэр гарсан; 119.1.2. шүүхийн, эсхүл хөдөлмөрийн эрхийн маргаан шийдвэрлэх байгууллагын шийдвэр хүчин төгөлдөр болсон; 119.1.3. ажилтанд энэ хуулийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

123.2.3-т заасан хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулсан; 119.1.4. хууль тогтоомжид заасан бусад тохиолдол" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажилчдаас илүү суутгаж авсан цалинг ажилчдад буцаан олгох төлбөрийн акт тогтоов

5.2 Албан шаардлага

1. Нийгмийн даатгалд 985.6 мянган төгрөгийн цалинг дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу тайлагнасан цалинг нийгмийн даатгалд нөхөн тайлагнах албан шаардлага хүргүүлсэн.

2. Ажлаас чөлөөлөгдсөн 7 ажилтантай амралтын цалингийн дуусгалын тооцоо хийгээгүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 83 дугаар зүйлийг 83.1-т "Ажил олгогч ажилтны ажлын байрыг хэвээр хадгалах тохиолдолд ажлыг нь түр, хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон тохиолдолд бүрмөсөн хүлээн авна", 110 дугаар зүйлийн 110.3-т "Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалын хавсралт "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 2.8-т "Ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах, дуусгавар болгох үед ажил олгогч нь ажилтантай ээлжийн амралтын тооцоог дараах байдлаар хийнэ. Үүнд: ажилтанд ажилласан хугацаанд нь ногдох ээлжийн амралтын цалинг олгох; ажилтнаас илүү олгосон ээлжийн амралтын цалингийн суутгалыг хийх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэлт: Ажлаас чөлөөлөгдсөн ажилтанд амралтын цалингийн дуусгалын тооцоог хууль журмын дагуу хийж байх албан шаардлага хүргүүлсэн

3. Эдийн засгийн ангилал зөрчиж багаж хэрэгсэлийн төсвөөс 8,222.5 мянган төгрөгийн бичиг хэрэг, урсгал засварын материалд, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн төсвөөс 3,246.0 мянган төгрөгийг цалингийн нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг ангиллын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаа гүй		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Говийн их дархан цаазат газрын "Б" хэсгийн хамгаалалтын захиргаа	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг 11,792.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	11,792.5	-	-	1	11,792.5	1	11,792.5	-	-	-	-
	Бараа материалын тодруулга тайланд 31,995.0 мянган төгрөгийн өвс, хатуу түлшийг зөрүүтэй тайлагнасан	1	31,995.0	-	-	1	31,995.0	1	31,995.0	-	-	-	-
	Бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 15,000.0 мянган төгрөгийн гүйлгээ байна	1	15,000.0	1	15,000.0	-	-	0	15,000.0	-	-	-	-
	Дүн	3	58,787.5	1	15,000.0	2	43,787.5	2	58,787.5	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл				/мянган төгрөгөөр/							
Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
	Ажилчдын үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 1,020.9 мянган төгрөгийг олгосон	1	1,020.9	1	1,020.9	-	-	-	-	-	-

Говийн их дархан цаазат газрын "Б" хэсгийн хамгаалалтын захиргаа	Ажилчдын цалингаас аудитын акт суутгахдаа 420.5 мянган төгрөгийг илүү суутгасан.	1	420.5	1	420.5	-	-	-	-	-	-
	Нийгмийн даатгалд 985.6 мянган төгрөгийн цалинг дутуу тайлагнасан.	1	985.6	-	-	-	985.6	-	-	-	-
	Эдийн засгийн ангилал зөрчиж багаж хэрэгсэлээс 8,222.5 мянган төгрөгийн бичиг хэрэг, урсгал засварын материалд, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлээс цалингийн нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулсан.	1	11,471.0	-	-	-	11,471.0	-	-	-	-
	Ажлаас чөлөөлөгдсөн 7 ажилтанд амралтын цалингийн дуусгалын тооцоо хийгээгүй.	1	-	-	-	-	-	-	-	-	-
Нийт		5	13,898.0	2	1,441.4	3	12,456.6	-	-	-	-

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:						/мянган төгрөгөөр/	
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Тоо	Дүн	Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
1	2	3	4	5	6	7	8	9	10		
Говийн их дархан цаазат газрын "Б" хэсгийн хамгаалалтын захиргаа	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 29,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй тэвэр, шатахуун, 27,770.0 мянган төгрөгийн өвсний зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй.	1	56,770.0	-	-	1	56,770.0	-	-	-	-
	Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлогын 777,232.2 мянган төгрөгийн 12, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 5,000.0 төгрөгийн 1 гүйлгээг мэдээлээгүй, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 32,212.8 мянган төгрөгийн 4 шийдвэрийг хугацаа хоцорч мэдээлсэн.	1	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн		2	56,770.0	-	-	2	56,770.0	-	-	-	-